



МОНГОЛ УЛСЫН  
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2021 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.13 дахь хэсэг, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Сонгуулийн автоматжуулсан системийн автоматжуулах хэрэгслийн иж бүрдэлд гэмтэл, саатал гарсны улмаас гар ажиллагаанд шилжих журам"-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хорооны нарийн бичгийн дарга /Д.Даваа-Очир/-д даалгасугай.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны 2012 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн "Сонгуулийн автоматжуулсан системийн автоматжуулах хэрэгслийн иж бүрдэлд гэмтэл, саатал гарсны улмаас гар ажиллагаанд шилжих журам батлах тухай" 72 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

П.ДЭЛГЭРНАРАН

Д.ДАВАА-ОЧИР

00000035

Сонгуулийн ерөнхий хорооны  
2021 оны 2 дугаар сарын 2 ны өдрийн  
18 дугаар тогтоолын хавсралт



## СОНГУУЛИЙН АВТОМАТЖУУЛСАН СИСТЕМИЙН АВТОМАТЖУУЛАХ ХЭРЭГСЛИЙН ИЖ БҮРДЭЛД ГЭМТЭЛ, СААТАЛ ГАРСНЫ УЛМААС ГАР АЖИЛЛАГААНД ШИЛЖИХ ЖУРАМ

### *Нэг. Нийтлэг үндэслэл*

1.1. Энэхүү журам нь сонгуулийн автоматжуулсан системийн автоматжуулах хэрэгслийн иж бүрдэлд орсон техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, программ хангамжид гэмтэл, саатал гарч, түүнийг сэргээн ажиллуулах боломжгүй тохиолдолд санал авах, санал тоолох, санал хураалтын дүнг дамжуулах, сонгогчийг таньж баталгаажуулах, бүртгэх ажиллагааг гар ажиллагаанд шилжүүлэх үндэслэлийг тодорхойлж, холбогдох харилцааг зохицуулна.

1.2. Хэсгийн хороо сонгуулийн автоматжуулсан системийн автоматжуулах хэрэгслийн иж бүрдэлд орсон техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, программ хангамжид гэмтэл, саатал гарсан тохиолдолд тэр тухай тэмдэглэл үйлдэж, гарсан гэмтэл, саатлыг арилгах, техник хэрэгслийн ажиллагааг сэргээх арга хэмжээг шуурхай зохион байгуулна.

1.3. Хэрэв энэ журмын 1.2-т заасан арга хэмжээг авсан ч автоматжуулах хэрэгслийн иж бүрдэлд орсон техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, программ хангамж ажиллахгүй болсон, түүнийг өөр техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр солих, засварлах боломжгүй тохиолдолд Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан нөөц төлөвлөгөөний дагуу мэдээллийн ажиллагааг саадгүй үргэлжлүүлэн явуулах ажлыг зохион байгуулна.

1.4. Энэ журмын 1.2-т заасан арга хэмжээний дүнд гэмтэл, саатлыг арилгасан, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ажиллагааг сэргээсэн бол нэн даруй автоматжуулалтын горимд оруулна.

1.5. Энэ журмын 2.1-д заасан нөхцөл байдал бодитой үүссэн болохыг санал авах байранд ажиллах мэдээллийн технологийн даамал, улсын бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтан үнэлж, тэр тухай дүгнэлт гарган хэсгийн хороонд танилцуулна.

1.6. Энэ журмын 1.5-д заасны дагуу гаргасан дүгнэлтийг үндэслэн гар ажиллагаанд шилжүүлэх шийдвэрийг хэсгийн хорооны дарга гаргана.

1.7. Энэ журмын 2.1-т заасан нөхцөл санал тоолох төхөөрөмжид үүссэн бол мэдээллийн технологийн даамал нь мэдээллийн технологийн баг болон Мэдээллийн технологийн төвд мэдэгдэнэ. Мэдээллийн технологийн төв гэмтлийг тодорхойлж засах, хэвийн горимд шилжүүлэх ажлыг зохион байгуулна.

1.8. Энэ журмын 2.1-т заасан нөхцөл сонгогчийг таньж баталгаажуулах, бүртгэх төхөөрөмжид үүссэн бол улсын бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтан Улсын бүртгэлийн ерөнхий газрын шуурхай баг, Мэдээллийн технологийн газар гэмтлийг тодорхойлж хэвийн горимд шилжүүлэх ажлыг зохион байгуулна.

## **Хоёр. Автоматжуулалтыг зогсоож гар ажиллагаанд шилжүүлэх үндэслэл**

2.1. Сонгуулийн санал авах, санал тоолох, санал хураалтын дүнг дамжуулах, сонгогчийг таньж баталгаажуулах, бүртгэх явцад сонгуулийн автоматжуулсан системийн автоматжуулах хэрэгслийн иж бүрдлийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжид гэмтэл, саатал гарч, түүнийг сэргээн ажиллуулах боломжгүй дараахь нөхцөл байдал үүссэн үед автоматжуулалтыг зогсоож гар ажиллагаанд шилжүүлнэ:

2.1.1. цахилгаан хангамж тасарч, түүнийг сэргээх, бусад нөөц эх үүсвэрээс хангах боломжгүй болох;

2.1.2. санал тоолох төхөөрөмж, түүний бүрдэл хэсэг ажиллагаагүй болох, түүнийг сэргээх, нөөц төхөөрөмжөөр солих боломжгүй болох;

2.1.3. сонгуулийн автоматжуулсан системд ашиглаж буй сервер түүний программ хангамж ажиллагаагүй болох, гэмтэх, өөрчлөгдөх, түүнийг сэргээх, дахин суулгах боломжгүй болох;

2.1.4. сонгуулийн дүнг дамжуулах харилцаа холбооны суваг, техник хэрэгслийг ашиглах явцад гэмтэл, саатал гарч түүнийг сэргээх, өөр шийдлээр дамжуулах боломжгүй болох.

2.1.5. сонгогчийг таньж баталгаажуулах, бүртгэх программ хангамж, төхөөрөмж, түүний бүрдэл хэсэг ажиллагаагүй болох, түүнийг сэргээх, нөөц төхөөрөмжөөр солих боломжгүй болох.

### **Гурав. Цахилгаан эрчим хүчний хангамж тасарсан нөхцөлд гар ажиллагаанд шилжих**

3.1. Энэ журмын 2.1.1-д заасны дагуу цахилгаан эрчим хүчний хангамжгүй, сэргээх боломжгүй, нөөц эх үүсвэргүй болсон нөхцөлд сонгогчийг таньж баталгаажуулах, бүртгэх, санал авах, тоолох, дүнг гаргаж дамжуулах ажиллагааг гар ажиллагаанд шилжүүлнэ.

3.2. Гар ажиллагаанд шилжсэнээс хойш цахилгаан эрчим хүчний хангалт сэргэвэл сонгогчийг таньж баталгаажуулах төхөөрөмж, санал авах, санал тоолох төхөөрөмж, сервер түүний программ хангамж, харилцаа холбооны суваг, техник хэрэгслийг ажиллуулж автоматжуулсан горимд шилжинэ.

### **Дөрөв. Санал тоолох төхөөрөмж ажиллагаагүй болсон нөхцөлд гар ажиллагаанд шилжих**

4.1. Энэ журмын 2.1.2-т заасны дагуу санал тоолох төхөөрөмж, түүний бүрдэл хэсэг ажиллагаагүй болсон нөхцөлд саналын хуудсыг хүлээн авч, саналын хуудсыг тоолж сонгуулийн дүнг гаргах ажиллагааг гар аргаар хийж гүйцэтгэнэ.

4.2. Гар ажиллагаанд шилжихэд саналын хайрцаг дахь нөөц тасалгааны лацыг авч сонгогчдын санал авах ажлыг зохион байгуулна.

4.3. Гар ажиллагаанд шилжин санал авч байх үед санал авах, тоолох төхөөрөмжийг хэвийн ажиллагаанд оруулсан бол төхөөрөмжийг дахин ачаалж гар ажиллагаанаас автоматжуулсан горимд шилжүүлэх бөгөөд нөөц тасалгаан дахь саналын хуудсыг нэн даруй санал авах, тоолох төхөөрөмжид уншуулна.

4.4. Санал хураалт дуусахаас өмнө мэдээллийн технологийн баг нөөц санал тоолох төхөөрөмжийг авчирч ажиллагаанд оруулахдаа гэмтэл гарсан төхөөрөмжийн CF картыг ашиглаагүй бол тухайн саналын хайрцагт хийсэн нийт саналын хуудсыг санал тоолох төхөөрөмжийг сольсон даруйд уншуулна. Хэрэв нөөц санал тоолох

төхөөрөмжид гэмтэл гарсан төхөөрөмжийн CF картыг ашиглах бол нөөц тасалгаанд хийсэн саналын хуудсуудыг санал тоолох төхөөрөмжийг сольсон даруйд уншуулна.

4.5.Саналын хайрцаг дахь нөөц тасалгаа саналын хуудсаар дүүрсэн тохиолдолд зөөврийн битүүмжилсэн саналын хайрцагт саналын хуудсыг хийнэ. Ингэхдээ зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгийг ажиглагчдад үзүүлэн лацадсан байна.

**Тав. Санал хураалтын дүн дамжуулах боломжгүй болсон нөхцөлд гар ажиллагаанд шилжих**

5.1.Энэ журмын 2.1.3-т заасны дагуу сонгуулийн автоматжуулсан системд ашиглаж буй сервер түүний программ хангамж ажиллахгүй болсон тохиолдолд санал авах, тоолох төхөөрөмжөөс гарсан дүнг үзүүлэлт тус бүрээр Мэдээллийн технологийн төвд нэн даруй мэдэгдэнэ.

5.2.Энэ журмын 2.1.4-т заасны дагуу сонгуулийн дүнг дамжуулах харилцаа холбооны суваг, техник хэрэгсэлд гэмтэл, саатал гарсны улмаас дүнг дамжуулах боломжгүй болсон тохиолдолд санал авах, тоолох төхөөрөмжөөс гарсан дүнг үзүүлэлт тус бүрээр Мэдээллийн технологийн төвд нэн даруй мэдэгдэнэ.

5.3.Энэ журмын 5.1, 5.2-т заасны дагуу мэдэгдсэн дүнг буюу санал тоолох төхөөрөмжөөс гарсан дүнгийн хуудаст тухайн шатны сонгуулийн хорооны бүрэлдэхүүн гарын үсэг зурж, тэмдэг даран дээд шатны сонгуулийн хороонд хүргүүлнэ.

**Зургаа. Сонгогчийг таньж баталгаажуулах, бүртгэх программ хангамж, төхөөрөмж, түүний бүрдэл хэсэг ажиллагаагүй болсон нөхцөлд гар ажиллагаанд шилжих**

6.1.Энэ журмын 2.1.5-д заасны дагуу сонгогчийг таньж баталгаажуулах, бүртгэх программ хангамж, төхөөрөмж ажиллахгүй болсон нөхцөлд дор дурдсан ажиллагааг хийнэ.

6.1.1.сонгогчийг бүртгэхдээ сонгогчийн нэрийн жагсаалтын цаасан хувилбартай тулган шалгана.

6.1.2.улсын бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтан өөрийн албан хэрэгцээнд ашиглаж байгаа сонгогчийн нэрийн жагсаалтын цаасан хувилбараас саналаа өгөхөөр ирсэн сонгогчийн иргэний үнэмлэхний мэдээллийг тулган шалгаж тайлбар хэсэгт гарын үсэг зуруулна.

6.1.3.бүртгэлийн хуудсыг гараар бичиж эх хувийг итгэмжлэгдсэн ажилтан авч хуулбар хувийг хэсгийн хороонд өгнө. Уг бүртгэлийн хуудсанд тухайн сонгогчийн СНЖ-д бүртгэгдсэн дугаар, эцэг эхийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, шилжин ирсэн эсэх, бүртгэлийн хуудас олгосон огноо зэргийг бичиж хэсгийн хорооны дарга, итгэмжлэгдсэн ажилтан гарын үсэг зурна.

6.1.4.Гар ажиллагаанд шилжсэнээр олгосон бүртгэлийн хуудсыг нэг бүрчлэн тоолж, 2 хувь тэмдэглэл үйлдэн, хаалтын тайлан гаргахдаа программаас гаргасан тайлангийн хуудас дээр нэмж, 1 хувийг хэсгийн хорооны даргад өгнө.

6.2.Гар ажиллагаанд шилжин сонгогчийг бүртгэж байх үед сонгогчийг таньж баталгаажуулах, бүртгэх төхөөрөмж ажиллаж эхэлбэл гар ажиллагаанаас автоматжуулсан горимд шилжүүлнэ. Энэ тохиолдолд сонгогчийг бүртгэхдээ итгэмжлэгдсэн ажилтан албан хэрэгцээнд ашиглаж байгаа сонгогчийн нэрийн жагсаалтын цаасан хувилбар дээр гарын үсэг зурсан эсэхийг тулган шалгана.

### **Долоо.Санал тоолох, дүн гаргах**

7.1.Энэ журамд заасан үндэслэлийн дагуу гар ажиллагаанд шилжсэн бөгөөд санал хураалт дуусах хүртэл санал тоолох төхөөрөмжийг ажиллуулж, автоматжуулсан горимд шилжүүлэх боломжгүй болсон тохиолдолд санал тоолох, дүн гаргах ажиллагааг хяналтын тооллого хийх журамд заасны дагуу хийж гүйцэтгэнэ.

---oOo---